

Хөнгөн бетон ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны тайлан

Үйлдвэрлэлийн дотоод орчин:

1. Үйлдвэрлэлт ба тоног төхөөрөмж

Энэ онд бид **3514** м³ хөнгөн блок үйлдвэрлэж, **404,1** сая төгрөгийн борлуулалтын орлоготой байсан ба бэлэн мөнгөний хомсдолоос шалтгаалан бартераар төлбөр тооцоонууд хийгдэж жилээс жилд үйлдвэрлэлийн хэмжээ буурах хандлагатай болоод байна. Манай үйлдвэр нь анх 1967 онд байгуулагдсанаас хойш өнөөдрийн хүртэл томоохон шинэчлэлт огт хийгдээгүй ба тоног төхөөрөмж элэгдэж хуучирсан, зарим нь ашиглагдахаа больсон ба засварын зардал болоод ажиллах хүчний зардал маш өндөр, сэлбэг хэрэгсэлийн олдоц муудсаар байна. Мөн 2013 оноос улс орны болоод барилгын салбарын эдийн засгийн нөхцөл муудаж үйлдвэрлэлийн захиалга эрс буураад байгаа ба үйлдвэрлэлийг 2017 онд 1 ээлжээр 8 сар ажиллуулсан. 2017 онд үйл ажиллагааны зардал 259,1 сая төгрөгийн алдагдалтай ажиллалаа.

2. Түүхий эд материал

2017 онд түүхий эд материалын олдоц хүрэлцээтэй байсан боловч зарим тохиолдолд түүхий эдийн ялангуяа шохойн чанараас шалтгаалан үйлдвэрлэл зогсох тохиолдол гарч байсан ба түүхий эдийн үнэнд мэдэгдэхүйц бууралт гараагүй. 2013 онд Германаас импортлон нөөцөлсөн хөнгөн цагааны нунтаг дууссан бөгөөд мөнгөний дутагдалаас шалтгаалан дахин захиалж чадаагүй ба Хятад улсын хөнгөн цагааны нунтагыг бага багаар авч хэрэглэж байгаа нь бүтээгдэхүүний чанарт мөн нөлөөлсөн.

3. Хүний нөөц

Манай үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд нь гар ажиллагаа их байдаг учраас ажиллах хүчний асуудал маш чухалд тооцогддог ба бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь шууд хүнээс хамааралтай. Үйлдвэрлэлийн түвшинд ажилладаг ажилчид нь тогтвор суурьшилтай удаан ажилладаггүйгээс шалтгаалан шинэ ажилтанг дадлагажуулах хугацаа шаардлагатай байдаг. Мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа улирлын чанартай явагдаж байгаа учир өвлийн саруудад ажилгүй байх хугацаанд зарим ажилчдаа алдаж хавар үйлдвэрлэл эхлэх үед хүн хүчний хомсдол үүсдэгээс хугацаа мөн алдаж байна.

4. Тогтмол зардал

Цахилгаан, дулаан, уур усны зардал жилээс жилд нэмэгдэж байгаа тогтмол зардал өсч байгаа нь үйлдвэрлэлийн хэмжээг ихэсгэхгүй л бол алдагдалтай ажиллахад хүрээд байна. Үйлдвэрлэлийн хэмжээ ихсэх тусам тогтмол зардал буурдаг ч бид үйлдвэрлэлийн хэмжээг ихэсгэж чадахгүйд хүрээд байна.

Бүтээгдэхүүний өртөгт шууд орохгүй бусад тогтмол зардал нь **123,7** сая төгрөг ба үүнд удирдлага, ита, санхүү, борлуулалтын албаны цалин хөлс, ндш, ТУЗ-ын зардал, шуудан холбоо, элэгдэл, конторын ашиглалтын зардал, засвар үйлчилгээний зардал, татвар хураамжууд орсон болно. Ашиглалтын зардал нь биднээс шууд хамааралгүй өөрчлөгддөг ба 90 орчим хувь нь үйлдвэрлэлийн өртөгт 10 хувь нь зардалд шингэдэг. Мөн засварын

зардал нийт зардалд эзлэх хувь өндөр ба энэ нь сэлбэг хэрэгсэлийн олдоц муу, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж хуучирч элэгдсэнтэй холбоотой.

5. Банкны зээл

Бид 2013 онд ЕСББанкны санхүүжилтээр Хас банкаар дамжуулан 1,470,000 долларын зээл авсан ба 2014 онд 210,000 доллар төлж одоогийн байдлаар 1,260,000 долларын үлдэгдэлтэй байгаа ба валютын ханш огцом өсөж хүүгийн зардал болон, гадаад валютын ханшийн зөрүүний алдагдал ихэссээр байна. Энэхүү зээлийн үндсэн төлөлт гэрээний дагуу 2015 оны 10-р сард 184,400 доллар төлөгдөх байсан боловч хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан зээлээ төлж чадалгүй муу ангилалд ороод байгаа ба ХАС банк нь манай компанийг шүүхэд өгсөн байгаа. Мөн энэ онд нийт 316,6 сая төгрөгийн зээлийн хүүгийн зардал гарсан ба энэ нь валютын ханшийн өсөлттэй холбоотой өмнөх оныхоос өссөн, валютын зээлтэй холбоотой нийт ханшийн зөрүүний алдагдалтай байх тул бид Хас банкинд хандан одоо байгаа зээлийн үлдэгдэл болох 1,260,000 америк долларын зээлийг төгрөгт хөрвүүлэн долларын зээлийн хүү 395,000 ам.долларыг төгрөгийн зээлийн үлдэгдэл болох 333,323,870 төгрөгтэй нэгтгэн 5-аас дээш жилийн урт хугацаатай хүү нь 12 хувиас ихгүй эхний 12 сар үндсэн зээл төлөхгүй байх нөхцөлтэй банкны зээлэнд хөрвүүлэх санал тавиад байна.

Үйлдвэрлэлийн гадаад орчны нөлөөлөл:

Ойрын жилүүдэд барилгын салбарт хөнгөн блокны хэрэгцээ багасаж шинэ барилгууд бетон зуурмаг болоод бусад шинэ төрлийн дүүргэгч материал ашиглах нь ихэсэж байна. Мөн БНХАУ-ын хөрөнгө оруулалт, технологитой шинэ үйлдвэрүүд зах зээлд ихээр нэвтрэн орж өрсөлдөөн их болон бүтээгдэхүүний үнэ зах зээл дээр буурч байна. Монголын томоохон компаниудын нэг МАК ХХК нь Герман улсын бүрэн автомат хүчин чадал өндөртэй хөнгөн блокны үйлдвэр суурилуулан ашиглалтанд оруулан их хэмжээгээр үйлдвэрлэн зах зээлд үнийг огцом бууруулаад байгаа ба энэхүү үйлдвэр дангаараа хөнгөн блокны ихэнхи хэрэгцээг хангах учир бид одоогийн энэхүү хүчин чадал, тоног төхөөрөмжөөр өрсөлдөхөд хүнд болоод байна.

Манай компани нь 2017 оны 1-р сарын 01-нээс менежментийн түрээсээр “Бест Терминал” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд энэхүү гэрээ хэлцлийн үр дүнд үйл ажиллагаанд маань ахиц гарч байгаа тул цаашид сайжрах төлөвтэй гэж үзэж байна.

Гүйцэтгэх захирал  Д.Болор